



ЦАХИМ ГҮЙЛГЭЭНИЙ БАРИМТ

ШИЛЖҮҮЛЭГЧИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Банкны нэр: **ХасБанк**
Данс: **5001591175**
Нэр: **-**
Дүн: **50,436,500.00**
Валют: **MNT**

ХҮЛЭЭН АВАГЧИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Банкны нэр: **Голомт Банк**
Данс: **2205161326**
Нэр: **ЭРДЭНЭС ГАЗ ТӨСӨЛ**
Дүн: **50,436,500.00**
Валют: **MNT**

ГҮЙЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Гүйлгээний дугаар: **000002746142**

Гүйлгээний утга: **Санхүүжилт 10-р сар Эрдэнэс монгол**

Гүйлгээний шимтгэл: **500.00MNT**

Гүйлгээний хүсэлт илгээсэн: **erdenesmongol4**

Гүйлгээ баталсан: **erdenesmongol5**

Гүйлгээ хийсэн огноо: **2022-10-10**

Энэхүү цахим гүйлгээний баримтыг засварлах, Мэдээлэл өөрчлөх болон аливаа хууль бус зорилгоор ашиглахыг хориглоно.



Санхүү, нягтлан бодох бүртгэлийн
үйл ажиллагааны дотоод журмын хавсралт

МОНГОХ ХУССЭН ӨРГӨДӨЛ БА ТӨЛБӨРИЙН ХУСЭЛТ

Дугаар _____

Он сар өдөр 2022. 10. 07.

Төлбөрийн хэлбэр бэлнээр дансаар

Төлбөрийн нэхцөл урьдчилгаа төлбөрийн нэхэмжлэх үлдэгдэл төлбөрийн нэхэмжлэх бүгд төлбөр

НЭХЭМЖЛЭГЧ : Эрдэнэс гаф тохиийн нэгж НЭХЭМЖЛЭХИЙН ДУГААР : 224/61.

Төлбөрийн зориулалт : Төгрөгийн дагуу санхүүжлийн

Гэрээний дугаар : ЭМГЛ-20-2021. 12. 32

Мөнгөн дүн 50'436'500. 00 Мөнгөний нэгж : ₮ ; \$ тоглог

Мөнгөн дүн (үсгээр) Төвийн сая дөрөвөн зүүн зүгийн зураган
мень таваж зүүн тоглог.
Гүйлгээний утга Санхүүжлийн төр сар

Тайлбар : Гэрээний дагуу төлсөн дүн Гэрээний үлдэгдэл төлбөрийн дүн

Хэлтэс, газар, алба Төлбөр болон гэрээг хариуцсан хүний нэр
(гарын үсэг)

Хянасан хүний нэр
(гарын үсэг)

Хавсаргасан баримтууд
Нэхэмжлэх <input checked="" type="checkbox"/>
НОАТ падаан <input type="checkbox"/>
ХАЗ дугаар <input type="checkbox"/>
Зарлагын падаан <input type="checkbox"/>
Шаардах хуудас <input type="checkbox"/>
Гэрээ дүгнэсэн акт <input type="checkbox"/>
Тайлан <input type="checkbox"/>
Төсөв <input checked="" type="checkbox"/>
Нэмэлт баримт <input checked="" type="checkbox"/>

Д.Доржсүрэн
Доржсүрэн

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР

Хянасан :

Хянасан :

Төсөв хянасан:

Санхүү, хөрөнгө оруулалтын
газрын захирал

Ерөнхий нягтлан бодогч

Төлөвлөлт, шинжилгээний
хэлтсийн дарга

50 сая төгрөгөөс дээш

50 сая төгрөг мянган

Зардлын ангилаал

"ЭРДЭНЭС МОНГОЛ" ХХК-ИЙН БАТЛАГДСАН ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ

Зардал / Хөрөнгө оруулалтын нэр төрөл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хувь	ХБГүйцэтгэл
<u>Эрдэнэс санхүүжлийн төрсэ</u>	<u>1'046'202'660.</u>	<u>344'253'347.77</u>	<u>33%</u>	<u>58%</u>



ЭРДЭНЭС ГАЗ ТӨСӨЛ

РД: 9924132

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө 17 дугаар байр, Блю Скай тауэр.
4 дүгээр давхрын 409А тоот
Утас: +97675050501
Факс: +97675050502

2022.10.03 № 224/61
таний нийтийн

Г Санхүүжилт хүсэх тухай

“Эрдэнэс Монгол” ХХК-д

Баярбат - г

Онг


Зандага - г

Онг

*Сургалтогч талаар
төшигдүүгүйд чу!*

“Эрдэнэс газ” төслийн нэгжийн 2022 оны төсвийн тодотголоор нийт 1,046,202,660 төгрөгөөр батлагдсан.

Төслийн нэгжийн 10 дугаар сарын цалин болон үйл ажиллагааны зардалд **66,872,500.00** /жаран зургаан сая найман зуун далан хоёр мянга таван зуун төгрөг 00 мөнгө/ шаардлагатай байгаа тул уг санхүүжилтийг олгож манай ажилд туслалцаа үзүүлнэ үү.



Төслийн удирдагч

Д. Даваа

Хавсралт 1

“Эрдэнэс газ” төслийн 2022 оны 10 дугаар сарын
шаардлагатай санхүүжилт

Төгрөгөөр

№	Гүйлгээний утга	Дүн
1	Цалингийн зардал	33,140,000.00
2	Нийгмийн даатгал	4,140,500.00
3	Түрээс	3,300,000.00
4	Харилцаа холбоо /Интернэт, утас/	270,000.00
5	Машини аккумулятор	400,000.00
6	Дотоод томилолт /Сэлэнгэ аймаг/	2,961,000.00
7	Дотоод сургалт	6,000,000.00
8	Гадаад сургалт	10,436,000.00
9	Бусдаар гүйцэтгүүлэх ажил /Хуулийн фирмийн урьдчилгаа төлбөр/	6,000,000.00
10	Бусдаар гүйцэтгүүлэх ажил /цэвэрлэгээ/	225,000.00
	Дүн	66,872,500.00

Төслийн удирдагч



Д. Даваа

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2022 оны 10 дугаар сарын 03

№....

Улаанбаатар хот

Энэхүү Ажил гүйцэтгэх гэрээг /цаашид "Гэрээ" гэх/ нэг талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, С.Жамъян гүний гудамж, 8-р байр, 3 давхар, 301-3 тоот хаягт байрлалтай "Эрдэнэс Монгол" ХК-ийн харьяа "Эрдэнэс газ" төслийн нэгж /РД:9924132/, түүнийг төлөөлж Төслийн удирдагч албан тушаалтай Д.Даваа /цаашид "Захиалагч тал" гэх/, негеэ талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, 11-р хороолол, Мэйсон оффис төвийн 4 давхар, 401 тоот хаягт байрлалтай Өмгөөллийн "Зенит лекс" хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл /РД:6347513/, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал албан тушаалтай Г.Аззаяа /цаашид "Гүйцэтгэгч тал" гэх/ нар нь Монгол Улсын Иргэний хуулийн 343 дугаар зүйл болон бусад холбогдох заалтуудыг тус тус үндэслэн дор дурдсан нөхцөлүүдийг харилцан тохиролцож, энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь Захиалагчийн өгсөн зааварчилгааны дагуу захиалагч байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох, сайжруулах зорилгоор Байгалийн хий нийлүүлэх хоолойн төслийг дэмжих тухай хуулийн төсөл, хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлал, даган гарах журмын төслийг боловсруулах зөвлөх үйлчилгээг үзүүлэх, Захиалагч нь Гүйцэтгэгчийг мэргэжлийн удирдлага, мэдээллээр хангах, хэлэлцэн тохирсон үйлчилгээний хөлсийг төлөхтэй холбоотой талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлага болон тэдгээртэй холбоотой бусад харилцааг зохицуулна.

1.2. Гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд Талуудын удирдлага, зохион байгуулалт өөрчлөгдсөн эсэхээс үл хамааран гэрээ үйлчлэх хугацааны туршид хүчин төгөлдөр байна.

1.3. Гэрээт ажлын нууцлалтай холбоотой асуудлыг "Нууцлалын гэрээ"-ээр зохицуулах бөгөөд Нууцлалын гэрээ нь уг гэрээний салшгүй хэсэг байна.

1.4. Энэхүү гэрээнд зохицуулагдаагүй харилцааг Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1. Энэхүү гэрээгээр гүйцэтгэгч нь Монгол Улсын Их Хурлаас байгалийн хий нийлүүлэх хоолойн төслийг дэмжих тухай хууль батлагдах хүртэл хугацаанд Захиалагчид зөвлөх үйлчилгээ үзүүлнэ.

2.2. Хуулийн төсөл, хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлал, даган гарах журмын төслийг боловсруулах хугацаа нь гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш нэг сарын хугацаатай байна.

2.3. Шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцсоноор гэрээний хугацааг сунгаж болох бөгөөд энэ тухай нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэнэ.

2.4. Талууд бие биенхээ үйл ажиллагааг харилцан хүндэтгэж, гэрээний заалтуудыг чанд мөрдөнө.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

3.1 Гэрээний хүрээнд талууд хуулийн төсөл, хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлал, даган гарах журмын төслийг боловсруулах зөвлөх үйлчилгээг 18.000.000 сая төгрөг /арван найман сая/-өөр хийж гүйцэтгэхээр тохиролцсон болно. Үүнд НӨАТ багтсан болно.

3.2 Захиалагч нь гэрээ хүчин төгөлдөр болсноор төлбөрийн нэхэмжлэхийг үндэслэн гүйцэтгэгч талд ажлын урьдчилгаа хөлс 30% болох 6,000,000 /зургаан сая/ төгрөгийг олгоно.

3.3 Гүйцэтгэгч нь хуулийн төсөл, хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлал, даган гарах журмын төслийг боловсруулж, Захиалагчид ажлын үр дүнг албан бичгээр хүлээлгэн өгч тайлагнах бөгөөд Захиалагч ажлын үр дүнг хүлээн авснаас хойш ажлын 7 хоногт багтаан ажил үйлчилгээний үлдэгдэл төлбөрийг гүйцэтгэгчийн Худалдаа Хөгжлийн банк дахь 473026336 тоот дансанд шилжүүлнэ.

3.4 Энэхүү гэрээний хүрээнд хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр хийгдэх ажлын үнийн саналд өөрчлөлт оруулахаар бол талууд бие биедээ албан ёсоор мэдэгдэж, харилцан тохиролцсон тохиолдолд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Ажил гүйцэтгэгчийг ажлаа хийж гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.

4.2. Захиалагч нь ажил үйлчилгээний хөлсийг гэрээнд заасан хугацаанд телөх үүрэгтэй.

4.3. Гүйцэтгэсэн ажлын үр дүнг гэрээнд заасан хугацаанд хүлээн авах ба ажлын үр дүнг хүлээн авснаас хойших аливаа эрсдэлийг дангаар хариуцах үүрэгтэй.

4.4. Гүйцэтгэгчээс захиалгын ажлын явцын талаарх мэдээллийг авах, зааварчилгаа өгөх, хяналт тавих эрхтэй.

4.5. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн ажил, үүргээ гүйцэтгэхдээ алдаа, дутагдал гаргасан болон талууд харилцан тохиролцож гэрээний хугацаа сунгаснаас бусад тохиолдолд хугацаа хэтрүүлсэн бол Захиалагч нь энэхүү гэрээг нэг талын санаачлагчаар цуцлах эрхтэй.

4.6. Захиалагч нь ажлын үр дүнд доголдол илэрсэн тохиолдолд үр дүнг хүлээн авснаас хойш нэг сарын дотор тухайн доголдлыг арилгуулахаар гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

4.7. Гүйцэтгэсэн ажлын үр дүн доголдолтой бол ажил гүйцэтгэгчийн зардлаар уг доголдлыг арилгуулах, эсхүл ажлыг шинээр гүйцэтгүүлэхээр шаардах эрхтэй.

ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын дагуу мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэн гэрээнд заасан хугацаанд нь Захиалагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.

5.2. Гүйцэтгэсэн ажлын үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгөхөөс өмнө ажлын үр дүнд учирч болох эрсдэлийг дангаар хариуцах үүрэгтэй.

5.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биечлэн гүйцэтгэх, Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр үүргээ бусад этгээдэд шилжүүлэхгүй байх үүрэгтэй.

5.4. Гэрээт ажлыг гүйцэтгэхтэй холбоотой захиалагчаас ирүүлсэн материал, шуурхай мэдээ, мэдээлэл, заавар, чиглэл нь чанарын шаардлага хангахааргүй байвал энэ тухай нэн даруй мэдэгдэнэ.

5.5. Хэрэв гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн бус буюу зохих ёсоор биелүүлэх боломжгүй тохиолдолд, ажил гүйцэтгэхэд гарч буй саад бэрхшээлийн талаар захиалагчид нэн даруй мэдэгдэнэ.

5.6. Гэрээт ажлын хөлсийг хугацаандаа төлөх, гэрээний биелэлтэд хяналт тавих, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Захиалагч талаас шаардах эрхтэй.

5.7. Гэрээт ажлыг гүйцэтгэхтэй холбогдуулан захиалагч талын албаны хүмүүстэй уулзалт, ярилцлага хийх эрхтэй.

5.8. Ажил гүйцэтгэгч нь энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс Захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан аливаа хохирлыг дангаар хариуцан арилгах үүрэгтэй. Хэрэв захиалагч талын буруугаас хохирол учирсан бол гүйцэтгэгч хариуцлагаас чөлөөлөгднө.

ЗУРГАА. ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

6.1 Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал нь үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа зааж, бичгээр шаардлага тавих ба уг шаардлагыг биелүүлээгүйгээс үүдэн гарах хохирлыг буруутай тал хариуцнэ.

6.2 Талууд өөрийн буруутай үйлдлээс нөгөө талд болон гуравдагч этгээдэд хохирол учруулсан, нэмэлт ажил ба зардал гарсан тохиолдолд учруулсан хохирлыг буруутай тал бүрэн хариуцах үүрэгтэй.

ДОЛОО. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

7.1. Энэхүү гэрээ нь дор дурдсан үндэслэлээр дуусгавар болно. Үүнд:

7.1.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлснээр буюу гэрээний хугацаа дууссан;

7.1.2. Талууд харилцан тохиролцсоноор гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосон;

7.1.3. Аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөний улмаас нөгөө тал гэрээг цуцалсан.

7.2. Энэхүү гэрээний аль нэг тал гэрээнд заасан үүргээ зөрчсөн гэж үзвэл нөгөө тал нь зөрчлийг арилгуулах зорилгоор бичгэн шаардлагыг зөрчил гаргасан талд хүргүүлнэ. Хэрэв зөрчил гаргасан тал шаардлагыг хүлээн авсанаас хойш ажлын 10 (арав) хоногийн дотор зөрчлийг арилгаагүй эсхүл хариу ирүүлээгүй тохиолдолд, түүнд гэрээ цуцлах мэдэгдлийг хүргүүлж, нөгөө тал нь хугацаанаас нь өмнө цуцалж болно.

7.3. Ийнхүү гэрээ цуцлагдахад хүргэсэн гэм буруутай үйлдэл гаргасан тал гэрээ цуцалснаас нөгөө талд учирсан хохирлыг бүрэн хариуцна.

НАЙМ. БУСАД

8.1 Гэрээтэй холбогдон гарсан аливаа маргаан, үл ойлголцох байдлыг талууд харилцан тохиролцох, хүндэтгэлтэй байх зарчмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй нөхцөлд шүүхээр шийдвэрлүүлнэ.

8.2. Энэхүү гэрээг 2 эх хувиар үйлдэн гарын үсэг зурж, тамга даран батзлаа жуулснаар хүчин төгөлдөр болгох бөгөөд талуудад тус бүр нэг эх хувь хадгалагдана.

8.3. Гэрээний аль нэг талын удирдлага, үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт орсон ч энэхүү гэрээ хүчин төгөлдөр хэвээр байна.

8.4. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож, нэмэлт гэрээ байгуулсны үндсэн дээр шийдвэрлэнэ.

ЕС. ГЭНЭТИЙН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

9.1. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл, нөхцөл байдлын улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.

9.2. Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

9.3. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн, эсэргүүцлийн хөдөлгөөн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг талуудын хүсэл зоригтоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.

9.4. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлин нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцэх замаар шийдвэрлэнэ

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ГҮЙЦЭТГЭХИЙГ ТӨЛӨӨЛЖ:
Гүйцэтгэх захираШ

.....Г.Азаяа..... Г.Азаяа

УЛААНБААТАР
9021080721 634751

Утас: 99236779
И-мэйл: enkhzaya31@gmail.com

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
Төслийн удирдагч

.....Д.Даваа..... Д.Даваа

Утас: +976 75050501
Факс: +976 75050502
И-мэйл: davaa@erdenesgas.mn